

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3.	Аудитын тайлан	9
3.1	Ерөнхий зүйл	9
3.2	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4	Материаллаг байдал	10
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1	Мөнгөн хөрөнгө	10
3.5.2	Урьдчилгаа	11
3.5.3	Бараа материал	11
3.5.4	Үндсэн хөрөнгө	11
3.5.5	Богино хугацаат өр төлбөр	12
3.5.6	Засгийн газрын хувь оролцоо	12
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
3.7	Шилэн дансны мэдээлэл	14
3.8	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	14
3.9	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	14
3.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
4.	Менежментийн захидал	16
4.	5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР
ТАНАА

2021.03.25 № 01/387
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 21 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 97.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,206,867.0	1,538,187.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,957.4	42,942.4
34	УРЬДЧИЛГАА	0.0	9,225.1
35	БАРАА МАТЕРИАЛ	1,157,909.6	1,486,020.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,818,041.8	8,655,134.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,818,041.8	8,655,134.3
39200	Биет хөрөнгө	8,198,435.3	8,103,182.6
39300	Биет бус хөрөнгө	619,606.4	551,951.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,024,908.7	10,193,322.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,349.0	4,094.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,349.0	4,094.4
41400	Урьдчилж орсон орлого	2,349.0	4,094.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,022,559.7	10,189,227.7
51	Засгийн газрын хувь оролцоо	10,022,559.7	10,189,227.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,433,292.5	1,433,292.5
51200	Хуримтлагдсан үр дүн	6,244,695.5	6,411,363.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,344,571.7	2,344,571.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,024,908.7	10,193,322.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,863,807.5	8,485,413.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,731,137.5	1,106,646.2
120	Нийтлэг татварын бус орлого	5,731,137.5	1,106,646.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,132,670.0	7,378,767.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,022,734.7	8,277,017.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,022,734.7	8,277,017.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,590,494.2	6,848,240.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,531,097.1	3,853,256.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	447,338.8	484,670.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,526.7	241,641.6
2104	Хангамж, бараа материалын зардал	409,201.6	551,076.8
2105	Норматив зардал	7,033.8	13,791.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,935.0	107,245.4
2107	Томилолт, зочны зардал	83,470.5	30,205.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	464,753.0	328,001.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,206,137.7	1,238,350.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,432,240.6	1,428,777.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	841,072.7	208,396.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	288,009.4	39,540.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	553,063.3	168,855.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,208,150.4	8,675,550.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	1,275,757.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.0	1,275,757.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	0.0	1,275,757.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,037,547.2	19,134.3
120	Нийтлэг татварын бус орлого	4,037,547.2	19,134.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,170,603.2	7,380,659.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,009,898.5	8,467,787.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,009,898.5	8,467,787.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,535,588.3	5,763,848.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,531,133.8	3,855,445.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	447,170.0	484,670.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,246.4	243,914.5
2104	Хангамж, бараа материалын зардал	377,236.0	333,706.7
2105	Норматив зардал	251,338.1	240,549.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,838.2	148,667.3
2107	Томилолт, зочны зардал	85,173.4	30,205.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249,481.8	355,266.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,970.5	71,422.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,474,310.2	2,703,938.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	198,251.9	207,763.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	176,950.5	213,778.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	176,950.5	213,778.5
2200	Дотоод эх үүсвэрээр	176,950.5	213,778.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-176,950.5	-213,778.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,301.4	-6,015.0
	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	27,656.0	48,957.4
	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	48,957.4	42,942.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,469,496.4	0.0	9,469,496.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,469,496.4	0.0	9,469,496.4
Тайлант үеийн үр дүн	553,063.3	0.0	553,063.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,022,559.7	0.0	10,022,559.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,187.7	0.0	-2,187.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,020,372.0	0.0	10,020,372.0
Тайлант үеийн үр дүн	168,855.6	0.0	168,855.6
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,189,227.7	0.0	10,189,227.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,388,976,900.0	6,365,399,832.0	1,023,577,068.0	86.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,388,976,900.0	6,365,399,832.0	1,023,577,068.0	86.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,996,951,300.0	5,976,319,427.0	1,020,631,873.0	85.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,677,355,100.0	3,855,445,846.6	821,909,253.5	82.4
210101	Үндсэн цалин	2,817,358,800.0	2,426,522,034.8	390,836,765.2	86.1
210102	Нэмэгдэл	1,125,624,300.0	787,539,957.0	338,084,343.0	70.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	437,676,500.0	405,978,879.8	31,697,620.2	92.8
210104	Урамшуулал	296,695,500.0	235,404,974.9	61,290,525.1	79.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	641,225,900.0	484,670,741.9	156,555,158.1	75.6
210201	Тэтгэврийн даатгал	436,013,100.0	316,563,067.2	119,450,032.8	72.6
210202	Тэтгэмжийн даатгал	47,698,200.0	39,714,054.6	7,984,145.4	83.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	41,218,600.0	35,245,054.4	5,973,545.7	85.5
210204	Ажилгүйдлийн даатгал	10,049,600.0	8,220,918.2	1,828,681.8	81.8
210205	Эрүүл мэндийн даатгал	106,246,400.0	84,927,647.6	21,318,752.4	79.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,141,000.0	243,914,478.6	9,226,521.4	96.4
210301	Гэрэл, цахилгаан	77,732,800.0	72,306,365.2	5,426,434.8	93.0
210302	Түлш, халаалт	71,469,800.0	69,139,318.4	2,330,481.6	96.7
210303	Цэвэр, бохир ус	10,175,400.0	9,409,569.0	765,831.0	92.5
210304	Байрны түрээс	93,763,000.0	93,059,226.0	703,774.0	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	334,115,500.0	332,812,727.9	1,302,772.1	99.6
210401	Бичиг хэрэг	46,007,800.0	45,617,571.0	390,229.0	99.2
210402	Тээвэр, шатахуун	163,656,300.0	163,653,810.0	2,490.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,954,200.0	44,295,248.9	658,951.1	98.5
210404	Ном, хэвлэл	11,222,500.0	11,150,300.0	72,200.0	99.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,274,700.0	68,095,798.0	178,902.0	99.7
2105	Норматив зардал	243,839,700.0	240,549,750.0	3,289,950.0	98.7

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,022,100.0	5,019,750.0	2,350.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	238,817,600.0	235,530,000.0	3,287,600.0	98.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	351,193,600.0	332,145,754.0	19,047,846.0	94.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	182,622,400.0	181,766,679.0	855,721.0	99.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	51,505,500.0	51,500,500.0	5,000.0	100.0
210604	Урсгал засвар	117,065,700.0	98,878,575.0	18,187,125.0	84.5
2107	Томилолт, зочны зардал	36,146,100.0	30,205,600.0	5,940,500.0	83.6
210702	Дотоод албан томилолт	32,346,100.0	28,116,900.0	4,229,200.0	86.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,800,000.0	2,088,700.0	1,711,300.0	55.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	388,843,400.0	385,566,148.5	3,277,251.5	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,607,600.0	224,410,635.0	3,196,965.0	98.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,340,000.0	2,340,000.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	26,248,500.0	26,248,324.0	176.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,190,300.0	3,188,441.0	1,859.0	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	737,800.0	736,534.0	1,266.0	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	103,966,400.0	103,924,007.5	42,392.5	100.0
210807	Газрын төлбөр	1,524,800.0	1,490,970.0	33,830.0	97.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,228,000.0	23,227,237.0	763.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,091,000.0	71,008,379.5	82,620.5	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,366,600.0	54,284,027.5	82,572.5	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,724,400.0	16,724,352.0	48.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	392,025,600.0	389,080,405.0	2,945,195.0	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	392,025,600.0	389,080,405.0	2,945,195.0	99.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	119,986,600.0	119,005,185.0	981,415.0	99.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,000,000.0	27,997,137.0	2,863.0	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	225,884,300.0	225,858,083.0	26,217.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,154,700.0	16,220,000.0	1,934,700.0	89.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,388,976,900.0	6,365,399,832.0	1,023,577,068.0	86.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,378,976,900.0	6,354,933,272.0	1,024,043,628.0	86.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	7,378,976,900.0	6,354,933,272.0	1,024,043,628.0	86.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.0	10,466,560.0	-466,560.0	104.7

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.0	10,466,560.0	-466,560.0	104.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	619	587	32	94.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7	0	100.0
610001	Төсвийн байгууллага	7	7	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	306	290	16	94.8
620001	Удирдах ажилтан	2	2	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	210	195	15	92.9
620003	Үйлчлэх ажилтан	94	93	1	98.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	306	290	16	94.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	216	201	15	93.1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	90	89	1	98.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,437,770.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,437,770.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,307,770.0
2104	Хангамж, бараа материалын зардал	893,980.0
210402	Тээвэр, шатахуун	132,460.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	413,790.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	413,790.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,130,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,130,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,130,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,437,770.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,437,770.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	546,250.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,891,520.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Д.Мөнхжин нар гүйцэтгэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/330 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чанартай, шуурхай, хүртээмжтэй, нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх;
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах;
- Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг шат дараатайгаар дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төсөвлөх, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үйл ажиллагаандаа мэдээлэл, технологийн дэвшилтэт техникийг нэвтрүүлэх;
- Хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж, үр дүнд үнэлгээ өгөх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол зохион байгуулж албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гадаадын иргэн, харьяатын газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, журмын дагуу шинэчилсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс нь 2020 онд харьяа 6 газрын санхүүгийн үйл ажиллагаанд 5 төлөвлөгөөт, 1 төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 42 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж ажилласан байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 11,022.7 сая төгрөгийн 2.0 хувь буюу 220.5 сая төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үйл ажиллагааны зардлын дүн 8,277.0 сая төгрөгийн 2.0 хувиар буюу 165.5 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 49.0 сая, эцсийн үлдэгдэл 42.9 сая төгрөг болж, 6.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	48.4	41.7	-6.7	97.2
Арилжааны банк дахь харилцах	0.6	1.2	0.6	2.8
Дүн	49.0	42.9	-6.1	100.0

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1.1 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 1.2 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд, 40.6 сая төгрөг ахмадын сангийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Бэлэн мөнгөний 5.1 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй. /ГИХГ-ын Зүүн бүс дэх газар/
- Анхан шатны баримтын бүрдэлгүй 1.5 сая төгрөгийн томилолтын зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан. /ГИХГ-ын Хойд бүс дэх газар/

3.5.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 9.2 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт №2. Урьдчилгаа дансны үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.0	9.2	9.2
Дүн	0.0	9.2	9.2

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардалд даатгалын 5.0 сая, авто зогсоолын түрээсийн урьдчилгаа төлбөр 4.2 сая төгрөг бүртгэлтэй байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,157.9 сая, эцсийн үлдэгдэл 1,486.0 сая төгрөг болж, 328.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	2.8	60.3	57.5
Эм боох материал	2.8	60.3	57.5
Хангамжийн материал	1,155.1	1,425.7	270.6
Бичиг хэргийн материал	34.3	36.6	2.3
Аж ахуйн материал	188.2	166.5	-21.7
Сэлбэг хэрэгсэл	8.5	5.2	-3.3
Түлш, шатах тослох материал	44.5	61.5	17.0
Барилгын засварын материал	1.9	1.5	-0.4
Бусад хангамжийн материал	877.7	1,154.4	276.7
Дүн	1,157.9	1,486.0	328.1

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал өмнөх оноос өссөн нь МХЕГ болон ХЗДХЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан эм боох материал, 235.5 сая төгрөгийн нормын хувцас худалдаж авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Оны эцэст шатах тослох материалыг их хэмжээгээр нөөцөлсөн байна. /ГИХГ-ын Баруун бүс дэх газар/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,818.0 сая, эцсийн үлдэгдэл 8,655.1 сая төгрөг болж, 162.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,198.4	8,103.2	-95.2
Барилга, байгууламж, орон сууц	6424.0	6437.9	13.8
Хуримтлагдсан элэгдэл	-175.3	-339.4	-164.0
Авто-тээврийн хэрэгсэл	1661.9	1583.1	-78.8
Хуримтлагдсан элэгдэл	-867.9	-753.0	114.9
Машин тоног			
төхөөрөмж(компьютер)	3225.4	2807.8	-417.6
Хуримтлагдсан элэгдэл	-2282.1	-1875.5	406.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	478.2	432.9	-45.2
Хуримтлагдсан элэгдэл	-356.8	-279.7	77.1

Зам, гүүрийн байгууламж	67.1	67.1	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-10.1	-12.1	-2.0
Бусад үндсэн хөрөнгө	57.8	58.2	0.3
Хуримтлагдсан элэгдэл	-30.0	-30.4	-0.4
Ном	6.3	6.3	0.0
Биет бус хөрөнгө	619.6	551.9	-67.7
Программ хангамж	557.1	475.2	-81.9
Хуримтлагдсан элэгдэл	-401.7	-354.6	47.1
Бусад биет бус хөрөнгө	542.5	565.5	23.0
Хуримтлагдсан элэгдэл	-78.3	-134.2	-55.9
Дүн	8,818.0	8,655.1	-162.9

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 213.8 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 422.5 сая, хөрөнгийн дахин үнэлгээгээр 530.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 173.0 сая, акталсан 385.0 сая, хөрөнгийн дахин үнэлгээгээр 1,195.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг байгууллагын нэр дээр шилжүүлж, үндсэн хөрөнгөд орлого аваагүй. /ГИХГ-ын Хойд бүс дэх газар/
- Байгууллагын өмч хөрөнгийн тооллого хийхэд зарим нэр төрлийн хөрөнгө биетээр оршин байхгүй. /ГИХГ-ын Баруун бүс дэх газар/
- Тайлант онд худалдан авсан 1.5 сая төгрөгийн сейф, сандал зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. /ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газар/

3.5.5 Богино хугацаат өр төлбөр

Хүснэгт №5. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	2.3	4.1	1.8
Урьдчилж орсон орлого	2.3	4.1	1.8
Засгийн газрын байгууллага, бусад шатын төсөв		0.6	0.6
Барьцаа, дэнчингийн урьдчилж орлого	2.3	3.5	1.2
Дүн	2.3	4.1	1.8

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж орсон орлогын үлдэгдэлд барьцааны дансны өглөг 2.0 сая, нэр данс зөрүүтэй гүйлгээ 0.3 сая, түрээсийн гэрээний барьцаа хөрөнгө 1.2 сая, улсын тэмдэгтийн хураамжийн урьдчилж орсон орлого 0.6 сая төгрөг байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 10,022.6 сая, эцсийн үлдэгдэл 10,189.2 сая төгрөг болж, 166.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал				
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,433.3	1,433.3	0.0	14.1
Хуримтлагдсан үр дүн	6,244.7	6,411.3	166.6	62.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,344.6	2,344.6	0.0	23.0
Дүн	10,022.6	10,189.2	166.6	100.0

Эх сурвалж: Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлт тайлант оны үр дүн 168.8 сая төгрөгөөр нэмэгдэж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 2.2 сая төгрөгөөр хасагдсан шалтгаалсан байна.

Тайлант онд өмнөх оны хувь хүний орлогын албан татварын өр төлбөр 2.2 сая төгрөгийг залруулж бүртгэсэн нь өмнөх үеийн үр дүнд нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9,169.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 9,169.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,439.5 сая төгрөгөөр бууруулж 7,729.8 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон хөрөнгийн зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 7,389.0 сая төгрөгийн төсөв урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 7,379.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,378.2 сая төгрөг санхүүжигдэж, 0.8 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 10.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 0.5 сая төгрөгөөр давсан нь Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн, харьяатын газрын түрээсийн орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,365.4 сая төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь дутуу орон тоотой ажилласнаас цалингийн зардал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,023.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Дорнод болон Дорноговь аймгийн ЗДТГ-аас 0.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.9 сая, нийт 2.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 1.3 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Нэр бүхий байгууллагаас нийт 14 удаагийн гүйлгээгээр 16.3 сая төгрөгийн аж ахуйн материал худалдаж авсан байна. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд тендер зарлаагүй, үнийн харьцуулалт хийгээгүй худалдан авалт байна. /ГИГХ/
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүй бараа үйлчилгээний бусад зардлаас албан томилолтын зардалд 0.4 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан. /ГИХГ-ын Хойд бүс дэх газар/

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1058 мэдээллээс 1043 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 38.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 68.1 сая төгрөгийн 9 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 1 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	38.0	5	38.0	100
Зөвлөмж	9	68.1	9	68.1	93.3
Нийт	14	106.1	14	106.1	96.7

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 344.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 319.6 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 2.0 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 22.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүллээ.

Гадаадын иргэн, харьяатын газар:

Залруулга

Санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв.Үүнд:

- Гэнэтийн осол, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын болон хөрөнгийн даатгалын зардлыг аккрузал сууриар тайлант онд ногдох зардлыг хуваарилж бүртгээгүй 5.0 сая төгрөг.
- Авто зогсоолын түрээсийн 7.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн 4.2 сая төгрөг.

Албан шаардлага

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.9-т заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлэн захирагчийн харьяа түүврээр хамрагдсан төсвийн шууд захирагчдад өгсөн 16.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 16.3 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авахдаа /14 удаагийн худалдан авалт/ харьцуулалтын арга хэрэглээгүй, шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ” тогтоолын заалтуудтай нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтыг жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа босго үнийг мөрдөж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

4. 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.03.25			САГ-2021/12/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гадаадын иргэн, харьяатын газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Гадаадын иргэн, харьяатын газар					
1	Нэр бүхий байгууллагаас нийт 14 удаагийн гүйлгээгээр 16.3 сая төгрөгийн аж ахуйн материал худалдаж авсан байна. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд тендер зарлаагүй, үнийн харьцуулалт хийгээгүй худалдан авалт байна.	16.3	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын дарга СХҮГ-ын дарга	Н.Ууганбаяр Ж.Солонго
2	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	ГИХГ-ын дарга СХҮГ-ын дарга	Н.Ууганбаяр Ж.Солонго
Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газар					
3	2020 оны эцэст шатах тослох материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн их хэмжээгээр нөөцөлсөн зөрчил байна.	-	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Баруун бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	А.Хуанбай П.Бүрэнбат
4	Байгууллагын өмч хөрөнгийн тооллого хийхэд зарим нэг төрлийн хөрөнгө биетээр оршин байхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Баруун бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	А.Хуанбай П.Бүрэнбат
5	Худалдан авах ажиллагааны тайлан, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт болон бусад мэдээллийг зарим саруудад бүрэн байршуулаагүй, оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн мөнгийг	-	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Баруун бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	А.Хуанбай П.Бүрэнбат

	мэдээлээгүй, мэдээлэл оруулахдаа “байхгүй” гэсэн утгаар мэдээлсэн.				
Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газар					
6	Кассын тайлан Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-аар батлагдсан маягтын дагуу илэрхийлээгүй.	5.1	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Төрхүү Х.Хэрлэн-Урсгал
Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар					
7	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр томилолтын зардлын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1.5	Албан шаардлага өгөх	ГИХГ-ын Хойд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Б.Мөнхбат Б.Тунгалагтуяа
8	Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр буюу төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр бараа үйлчилгээний бусад зардлаас албан томилолтын зардалд гүйлгэн зарцуулсан.	0.4	Албан шаардлага өгөх	ГИХГ-ын Хойд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Б.Мөнхбат Б.Тунгалагтуяа
9	Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг байгууллагын нэр дээр шилжүүлж, үндсэн хөрөнгөд орлого аваагүй.	-	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Хойд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Б.Мөнхбат Б.Тунгалагтуяа
10	Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Хойд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Б.Мөнхбат Б.Тунгалагтуяа
Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар					
11	Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 мэдээллийг 4.9 сая төгрөгөөр зөрүүтэй, зарлагын 67.4 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй.	-	Албан шаардлага өгөх	ГИХГ-ын Өмнөд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Ц.Дамдинсүрэн Ж.Ганчимэг

12	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан Жишиг норм батлах тухай тушаалын хавсралтад заасан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормд заасныг баримталж ажиллаагүй.	0.1	Албан шаардлага өгөх	ГИХГ-ын Өмнөд бүс дэх газрын дарга Нягтлан бодогч	Ц.Дамдинсүрэн Ж.Ганчимэг
Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар					
13	Тайлант онд худалдан авсан хөрөнгө болох сейф, сандал зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1.5	Зөвлөмж өгөх	ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газрын дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэбаатар Б.Болормаа
	Дүн	24.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 09 дугаар сарын 25

№ 419/АДН-0071

Улаанбаатар хот

САГ-2021/163/СТН-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гадаадын иргэн, харьяатын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Я.САМБУУНЯМ
Б.ЭНХЖИН
Д.МӨНХЖИН

[illegible]

This image shows a full page of a document template designed for handwriting practice or general note-taking. It consists of approximately 28 evenly spaced horizontal dotted lines across the entire width of the page. The background is plain white, and there are no margins, headers, footers, or other markings present.

[illegible]